



УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК

**ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БАРАА (БРОШЮР,
ТАРААХ МАТЕРИАЛ) НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧИГ**

**Тендерийн нэр: Дотоодын үйлдвэрлэлийн бараа (брошюр, тараах материал)
Тендерийн дугаар: ХА-046/2020**

Улаанбаатар хот - 2020 он

ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендерийн нэр: **Дотоодын үйлдвэрлэлийн бараа (брошюр, тараах материал)**
Тендерийн дугаар: **ХА-046/2020**

“УБЦТС” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос: **“Дотоодын үйлдвэрлэлийн бараа (брошюр, тараах материал)”** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг **2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 09 цаг 10 минутад** тендерийн нээлтийн өрөөнд нээнэ. /УБЦТС ТӨХК-н төв байрны 206 тоот/

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Захиалагчийн хаяг:
Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо,
Чингисийн өргөн чөлөө-45.
УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот.
Хангамж үйлчилгээний алба
Утас: 342420 +157, Факс: 976-341852
Цахим хаяг: www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Төсөвт өртөг 26,400,000 төгрөг 2. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Тендер нээсэн өдрийн байдлаар татвар, хураамж, төлбөрийг шалгах бөгөөд аливаа төлбөрийн өртэй байх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. 3. Улсын бүртгэлийн гэрчилгээ 4. Үнийн санал, бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу ирүүлэх 5. Шүүхийн тодорхойлолт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг ирүүлнэ. 6. Гэрээний үнээр, захиалгын хугацаанд шаардлага хангасан брошюр, тараах материалыг хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлнэ. 7. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. 8. Дотоодын үйлдвэрлэлийн бараа тул гадаадад үйлдвэрлэн нийлүүлэх тендерийн саналаас татгалзана 9. Брошюр, тараах материалыг буруу хэвлэж ирүүлсэн тохиолдолд нийлүүлэгч өөрийн зардлаар хохирлыг барагдуулах бөгөөд хохирлыг барагдуулахыг баталсан тухай албан мэдэгдэл ирүүлнэ. 10. Тухайн төрлийн хэвлэмэл материалыг өөрөө үйлдвэрлэгч болохыг нотлох баримт ирүүлнэ. 11. Чанарын баталгааны хугацаа: 6 сар байна. <p>Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан материалуудын аль нэгийг үнийн саналд хавсаргаж ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>

<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 09 цаг 10 минутад тендерийн нээлтийн өрөөнд нээнэ./УБЦТС ТӨХК-н төв байрны 206 тоот/ Захиалагчийн хаяг: Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө 45. УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот. Хангамж үйлчилгээний алба Утас: 342420 +157, Факс: 976-341852 Цахим хаяг: www.tender.gov.mn</p>
<p>ТӨӨЗ 2.3</p>	<p>Хувь хүний нууцын тухай болон байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, баталгаажуулсан мэдэгдлийн хамт ирүүлнэ. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>

Гурав. Брошюр, тараах материал тавигдах шаардлага

№	Хэвлүүлэх материалын нэр	Техникийн тодорхойлолт	Тоо хэмжээ
1	Тарифын хөнгөлөлт	A4 хэмжээтэй, өнгөт, 157 гр-ын шохойтой цаас, ар өвөргүй, 1 нугалбартай	25000
2	Үнэ тариф	A5 хэмжээтэй, өнгөт, 157 гр-ын шохойтой цаас, ар өвөргүй, 1 нугалбартай	7000
3	Цахим үйлчилгээ my.tog.mn, /ардаа циклтэй/	A5 хэмжээтэй, өнгөт, 157 гр-ын шохойтой цаас, ар өвөргүй, 1 нугалбартай	10000
4	137004 харилцах сувагтай	A4-ийн цаасыг 1/3 хэмжээтэй, өнгөт, 157 гр-ын шохойтой цаас, ар өвөргүй, нугалбаргүй	20000
5	Хэрэглэгчтэй харилцах сувгууд	A5 хэмжээтэй, өнгөт, 157 гр-ын шохойтой цаас, 1 нүүр, бүрэлттэй, ардаа наалттай	5000
6	ЦДАШ, дэд станц хүлээлгэн өгөхөд бүрдүүлэх материал	B5, /21*10/ өнгөт, 157 гр-ын шохойтой цаас, ар өвөргүй, 1 нугалбартай	5000
7	Техникийн нөхцөл авах, сүлжээнд шинээр холбогдох	A4-ийн 2/3 хэмжээтэй /21*20/, өнгөт, 157 гр-ын шохойтой цаас, 1 нугалбартай, ар өвөргүй	4000
8	Борлуулалт хүлээлгэн өгөх тухай	A5 хэмжээтэй, 4+4 өнгөтэй, 157 гр-ын шохойтой цаас, ар өвөргүй, 1 нугалбартай	4000
9	Цахилгааны аюулаас болгоомжлоорой /хүүхдийнх/	A4 хэмжээтэй, өнгөт, 157 гр-ын шохойтой цаас, ар өвөргүй, 1 нугалбартай	10000
10	Хүүхдүүдээ, цахилгааны аюулаас болгоомжлоорой плакат	30*42 хэмжээтэй, өнгөт, 250гр/м2 шохойтой цаас ардаа 2 захаараа наалттай, 1 нүүр	1000
11	Цахилгааны аюулгүй байдлаа хангана уу	21*20 хэмжээтэй, өнгөт, 157 гр-ын шохойтой цаас, ар өвөргүй, нугалбаргүй	10000
12	Тоолуур хэмжих хэрэгслийн зөвлөмж брошюр	A4-ийн 2/3 хэмжээтэй /21*20/, өнгөт, 157 гр-ын шохойтой цаас, ар өвөргүй, 1 нугалбартай	4000
13	Хэмнэлт	A5 хэмжээтэй, 4 өнгөтэй, 157 гр-ын шохойтой цаас	4000
14	Хэрэглэгчийн нэрийн хуудас ардаа циклтэй	Нэрийн хуудасны хэмжээтэй /6*10/, өнгөт, 200 гр-ын матт цаас, ар өвөргүй, нугалбаргүй	50,000
15	Цахилгаан хэрэглэгч апп Qрау /шинээр бэлтгэх/	A5 хэмжээтэй, 4+4 өнгөт, 250 гр-ын цаас, /бүрэлттэй/, 1 нүүр, ардаа наалттай	5,000
16	Компанийн танилцуулга сэтгүүл /англи монгол/	A4 хэмжээтэй өнгөт, 128 гр/м2-ын матт цаас 35-40 хуудастай, ар өвөргүй	600
17	Дансны дугаартай түр зогсоолын тэмдэг /сэнжтэй/	Нэрийн хуудасны хэмжээтэй, өнгөт, 300гр-ын шохойтой цаас, ар өвөргүй	10000
18	Цахилгааны аюулгүй байдлаа хэрхэн хангах вэ? /Шүхэртэй/	A4-ийн 2/3 хэмжээтэй, өнгөт, 157гр-ын шохойтой цаас, ар өвөргүй, 1 нугалбартай	10000
19	Цахилгаан хэрэглэгчийн гарын авлага сэтгүүл	A4 хэмжээтэй, өнгөт, офсет 100гр/м2, 35 хуудастай	600
20	Бэлгийн тор /логотой/ бариултай	B2 хэмжээтэй, 4+0 өнгөт 250 гр-ын бүрэлттэй, матт	100
НИЙТ ДҮН			185300

Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

	Нэр	Тодорхойлолт, тайлбар	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
						Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Тарифын хөнгөлөлт	Техникийн тодорхойлолтоос харах	25,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
2	Үнэ тариф		7,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
3	Цахим үйлчилгээ my.tog.mn, /ардаа циклтэй/		10,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
4	137004 харилцах сувагтай		20,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
5	Хэрэглэгчтэй харилцах сувгууд		5,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
6	ЦДАШ, дэд станц хүлээлгэн өгөхөд бүрдүүлэх материал		5,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
7	Техникийн нөхцөл авах, сүлжээнд шинээр холбогдох		4,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
8	Борлуулалт хүлээлгэн өгөх тухай		4,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
9	Цахилгааны аюулаас болгоомжлоорой /хүүхдийнх/		10,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
10	Хүүхдүүдээ, цахилгааны аюулаас болгоомжлоорой плакат		1,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
11	Цахилгааны аюулгүй байдлаа хангана уу		10,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
12	Тоолуур хэмжих хэрэгслийн зөвлөмж брошюр		4,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
13	Хэмнэлт		4,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
14	Хэрэглэгчийн нэрийн хуудас ардаа циклтэй		50,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
15	Цахилгаан хэрэглэгч апп Qray /шинээр бэлтгэх/		5,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	

16	Компанийн танилцуулга сэтгүүл /англи монгол/		600	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
17	Дансны дугаартай түр зогсоолын тэмдэг /сэнжтэй/		10,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
18	Цахилгааны аюулгүй байдлаа хэрхэн хангах вэ? /Шүхэртэй/		10,000	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
19	Цахилгаан хэрэглэгчийн гарын авлага сэтгүүл		600	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
20	Бэлгийн тор /логотой/ бариултай		100	ш	УБЦТС ТӨХК-ийн төв агуулах	Гэрээ байгуулсан өдөр	Захиалгын хугацаанд	
	Нийт		185,300					

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн 95 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: хоногт гэрээний үнийн дүнгийн 0,1%</p> <p>Алдангийн нийт дүн: гэрээний үнийн дүнгийн 10%</p> |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]